



ХЭЛТЭС, АЛБА, ГАЗРЫН 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 06-НААС 11 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРҮҮДЭД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

МАЙРАМДАА - ДРҮҮЖЭ 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн Засаг даргын ээлжит шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах
2. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал зохион байгуулах
3. Орон нутгийн төрийн албан хаагчдын ирээдүйд чиглэсэн богино хугацааны сургалтын хөтөлбөрийн санал авах уулзалтад 2023 оны 11 сарын 07-ны өдөр цахимаар оролцох
4. Удирдлагын академиас зохион байгуулж буй “Чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага” сургалтад 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 сарын 14-ны өдөр хүртэл хамрагдах
5. НДХ, ЭМГ, ГХБХБГ, ГБХЗХГ, СХЗХ-ийн 10 сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах Комиссын хурлыг хийх, шалгалтыг 11 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулан тайлан болон шалгалтын дүнг ТАЗ-д хүргүүлэх
6. Төрийн захиргааны албан хаагчдын тангараг өргөх ажлын бэлтгэл хангах хүрээнд төрийн байгууллагуудад судалгаа авах
7. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах 70353511 утас, E-Mongolia, Цахим төв болон Тамгын газрын бичиг хэргийн ажлыг гүйцэтгэх.



ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 2023 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд туссан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний явцын тайланг гаргах, хуралдаанд оруулах
2. Хэлтэс байгууллагуудаар ТЖҮЧ-ийн 2023 оны байдлаар өссөн дүнгээр гаргасан хэрэгжилтийг хэлэлцүүлж, засварласныг нэгтгэх
3. УБ хотоос шилжин ирсэн иргэдийн мэдээлэл, банкны зээлийн мэдээлэлд шинжилгээ хийж ЭЗХЯ-нд хүргүүлэх
4. Хамтдаа Эрдэнэтэд хөгжье хөтөлбөрийн биелэлт гаргах
5. Таримал ойд тооллого явуулж, чанар, үр дүнг шалган дүгнэлт гаргах ойн санд шилжүүлэх Ажлын хэсэгт ажиллах
6. Дэлхийн банкны хотуудын төсөлтэй холбоотойгоор төслийн зөвлөх болон төслийн архитектор нар Эрдэнэт хотод хийсэн судалгаа болон орон сууцны төрлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийх, уулзалт зохион байгуулахад хамтран ажиллах



ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

7.Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал төслийн хүрээнд ЕСБХБ-ны төсөл хариуцсан менежер, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, төсөл хэрэгжилтийн зөвлөхүүд, болон төслийн Зөвлөх СВЕКО Дани, МонКонсалт компанийн зөвлөхүүд Орхон аймагт ажиллахад хамтран ажиллах, уулзалтууд зохион байгуулах





НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Хүүхэд хамгааллын тухай шинэчилсэн хуулийн талаар Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт сургалт явуулах
2. "Хамтдаа шалгая, хамгаалъя" аяны хүрээнд ГБХЗХГ, ОБГ-тай хамтран багуудын эрсдэлт нөхцөлийг үнэлгээг хийж, нэгтгэх
3. Төрийн албан хаагчдын дундах спортын 3 төрөлт тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулах удирдамж батлуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх
4. "Соёлыг түгээе" аяны үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сэдэвт сургалтыг СӨББ-ын багш нар болон үйлчилгээний байгууллагын албан хаагчдыг хамруулан зохион байгуулах
5. "Эрдэнэт хотын өдөр"-ийн Ажлын хэсгийг хуралдуулж, ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулах
6. Дархан-Уул аймагт 2023 оны 11 дүгээр сарын 06,07-ны өдрүүдэд зохион байгуулагдах "Төвийн бүсийн аймгуудыг хамруулсан "Монголын уламжлалт анагаах ухааны нөлөөлөл 2023" сургалтад хэлтсийн мэргэжилтэн хамрагдах
7. Эрүүл мэндийн байгууллагуудын тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах олон улсын өдрийг угтсан сарын аяны хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг зохион байгуулах



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Орон нутгийн 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж Сангийн яам, Статистикийн хэлтэст хүргүүлж, шилэн дансны цахим сайтад байршуулах
2. Төсөвт байгууллагуудын 11 дүгээр сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгох
3. Улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын гүйлгээг анхан шатны баримт бичгийг хянан Төрийн сангийн удирдлагын цахим системээр баталгаажуулах
4. Төсвийн байгууллагын нэмэлт дансны хүсэлтийг хүлээн авч зардал болон санхүүжилтийн эрхийг нээх





ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Орон нутгийн түвшинд үндэсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн төслийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хоёр ба гурван дугуйт тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөнийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хориглох аймгийн Засаг даргын захирамж гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх
3. Зам тээврийн яамны салбарын хяналтын газраас ирүүлсэн 04/12 удирдамжийн дагуу Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүн мэдээг гаргаж хүргүүлэх
4. Авто замын хяналтын улсын комисст ажиллах
5. Хот тохижуулах газарт төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, авто замын арчлалт болон машин механизмын бэлэн байдал, давс бодисын нөөцлөлтийн байдлыг шалгах
6. Цахим хөгжил харилцаа холбооны яамны салбарын хяналтын газраас ирүүлсэн 09/03 удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүн мэдээг гаргаж хүргүүлэх
7. "Ачит Ихт" ХХК, "Зэс Эрдэнийн хувь" ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдэд Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох болон нийтийн тээврийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийн мөрөөр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах.



ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн, Тамгын газрын шуурхай хурал, удирдлагын шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг гарган шуурхай хурлуудад танилцуулах
2. Шинээр батлагдаж гарсан хууль тогтоомжуудыг хяналтад аван холбогдох газруудад хүргүүлэх
3. Засгийн газрын цахим санд хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон ЗГҮАХ-ийн хэрэгжилтийг оруулах
4. ЗДҮАХ-ийн урьдчилсан гүйцэтгэлийг хэлтэс, байгууллагуудаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах

НАЙРАМДАА - ДРҮҮЖДА



ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.20 дугаар сургуулийн уурын зуухнаас 11 дүгээр цэцэрлэгийг холбосонтой холбоотойгоор системийг бүрэн холбож халаалтыг жигдрүүлэх

2.2024 онд шинээр барих 8 барилгын гадна ИШС-ний трасс гаргах. Техникийн нөхцөл авах ажлыг зохион байгуулах

3.17 дугаар сургуульд нэмэлт зуух засварлаж холболт хийж халаалтыг сайжруулан жигдрүүлэх ажлыг дуусгах

4.2024 оны Хөрөнгө оруулалтаар хийх ажлуудыг газар дээр нь үзлэг хэмжилт хийж зураг төслийг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх

НАЙРАМДААЛ-ДРЭЖДА



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Зарласан 4 тендерийг нээж, үнэлэх
 2. Орлогод нийцсэн орон сууцны байрны ажлыг зохион байгуулж ажиллах
 3. 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажлын зураг төсөв 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар ирээгүй байна. Үүнд:
 - Согоот багийн нутаг дэвсгэрийн орчныг сайжруулах тохижилтын ажил
 - Орон сууцны 6-р хорооллын 16,17-р байрны дунд тоглоомын талбай байгуулах
 - Уурхайчин багт Тамир зочид буудлын урдах УДХТ-ийг инженерийн шугам сүлжээнд холбох /дулаан механик/
 - Зэвсэгт хүчний 110 дугаар анги орчим авто замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг хийх
 - Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/
- Мөн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 ажлын хувьд худалдан авах эсэх нь тодорхойгүй байна.
1. Төлбөр хураах цэгийг нүүлгэх шилжүүлэх -200.0 сая төгрөг /Тендерийг 2 удаа зарласан боловч нэг ч тендер ирээгүй тендер амжилтгүй болсон. Зураг төсөвт өөрчлөлт оруулах эсвэл төсөвт өртөг нэмэгдэх эсэхэд тайлбар өгөх шаардлагатай/
 2. Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн гүний худагт насос худалдаж авах-5.0 сая төгрөг, /БТСГ-аас техникийн тодорхойлолтыг шаардсан боловч уг бараа нь 2023 оны төсвөөр хийгдсэн Өвлийн спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд спортын техник хэрэгсэл худалдаж авах /цасны буу 1ш, буран 1ш/ хөрөнгө оруулалтын бараатай хамт нийлүүлэгдсэн тул худалдан авах шаардлагагүй гэж мэдэгдээд байгаа. Цаашид уг ажлыг төлөвлөлтөөс хасах эсэхэд тайлбар өгөх шаардлагатай.



СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Албан ёсны статистикийн 2 төрлийн мэдээг 79 нэгжээс гаргуулан авч, боловсруулалт хийн ҮСХ-нд цахимаар хүргэх
2. Аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын оны эхний 10 сарын статистикийн танилцуулга, инфографик мэдээллийг бэлтгэн гаргаж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр тархаах, дүнг танилцуулах хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах
4. Баян-Өндөр сумын ЗДТГ-ын статистик хариуцсан ажилтан, 26 багийн Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нарыг чадавхжуулах зорилгоор “Хүн ам, өрхийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, хэрэглээ”, “Эдийн засгийн салбарын статистик мэдээг гаргах аргачлал, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулах
5. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны багтай хамтран ажиллаж, мэдээлэл цуглуулалтад дэмжлэг үзүүлэн ажиллах
7. Малын ашиг шим, нэмүү өртгийн тооцооны туршилтын судалгааны мэдээлэл цуглуулалт үргэлжлэн хийгдэнэ. Мэдээлэл цуглуулалт 11 дүгээр сарын 30 хүртэл үргэлжилнэ.
8. Гол нэрийн 66 төрлийн бүтээгдэхүүний 11 дүгээр сарын 01 дүгээр долоо хоногийн үнийг 198 цэгээс судалж, бүтээгдэхүүний үнийн харьцуулсан хүснэгтэн болон инфографик мэдээллийг бэлтгэн хэвлэмэл, цахим хэлбэрээр хэрэглэгчдэд тархаах
9. Өрхөд суурилсан 5 төрлийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг хуваарийн дагуу зохион байгуулж явуулна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

НАЙРАМДАА - ДРЧУЖДА

2023 он

